

## УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

<b>Хянасан огноо</b>	
<b>Хянасан мэргэжилтнүүдийн хувийн дугаар</b>	
<b>Дүгнэлт</b> <ul style="list-style-type: none"> <li>• Шийдвэрийн төсөл</li> <li>• Ололт, амжилттай тал</li> <li>• Дутагдалтай сул тал</li> <li>• Шаардлага</li> </ul>	

### НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, баганад мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамаарахгүй хэсгийг “*хамааралгүй*” гэж бөглөх.
- 1.2.7 дах хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
<b>1.1</b>	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Хатантүшиг трейд” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011020148
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Ашигт малтмал ашиглалт Алтны шороон орд
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	УБ хот, СХД, 20-р хороо, Сонсголон-25
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Нэр: Х.Ундрах Утас: 99101131 Mail: khatantushig@yahoo.com
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Х.Мөнхцэцэг, 99991131 muugii_ast@yahoo.com
<b>1.2</b>	1. Төслийн нэр	Шаазгайт, Жалга 1, 2 алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах

2. Төслийн харьяаллын байршил	Дархан-Уул аймаг, Шарын гол сум, Санжинт баг, Шаазгайтын хөндий
3. Төслийн ангилал а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт б. ил уурхай, далд уурхай, шороон орд с. баяжуулах үйлдвэр	а. алт б. ил уурхай с. Үүсмэл орд
4. Төсөл эхэлсэн огноо	2018-06-23
5. Төсөл хэрэгжих хугацаа	Олборлолт - 2 жил Хаалтын дараах мониторинг – 3 жил
6. Уурхайн хаалт эхлэх огноо	2026 он
7. Хаалтын дараах зориулалт	Хөдөө аж ахуй
8. ТЭЗҮ баталсан огноо	2022-03-02
9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	9 кг
10. Ажилчдын тоо	29
11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	17.920 мян.м3 элс олборлож, 3.036 кг алт борлуулна..
12. Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц • Замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл • Шатахуун түгээгүүрийн тоо • Шатахууны агуулахын агууламжийн хэмжээ • Тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт	• Уурхайн дотоод замын урт - 1.2км /уурхайн ам-уурхайн кемп/ • ШТМ-20тн-ны ёмкость

**ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын нөөц, ТЭЗҮ баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана	
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	Дугаар: MV-000396 Хүчинтэй хугацаа: 10 жил Талбай: 56.49 га	
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа	Хамааралгүй	
	3. Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	Хамааралгүй	
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар		
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2022-05-11, Дугаар 2022/ОА-66 БОНХАЖЯамны Ерөнхий шинжээч Г.Энхмөнх	
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2022 он БОНХАЖЯ-ны Ерөнхий шинжээч Г.Энхмөнх	
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	Монгол-Ус төрийн өмчит үйлдвэрийн газрын 2022.06.21-ний 174 тоот ус ашиглуулах дүгнэлт	
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	2024	
	9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягыг хавсаргах	Хавсаргав	
10. Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	Тайлант онд гүйцэтгэсэн	5.6 га
		Төлөвлөгөөт онд гүйцэтгэх	0.25 га
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	Тайлант онд гүйцэтгэсэн	6.45 га
		Төлөвлөгөөт онд гүйцэтгэх	-
11. ТХГН-ын тухай хууль, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын		Хавсаргасан	

	хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах	
--	---	--

## ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтанд тусгагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заасны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох мэдээллийг доорх хүснэгтэд оруулах
- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд химийн бодисын хор, аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хавсралтаар оруулж, доорх хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах (хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай)
- Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “хангалттай” гэсэн дүгнэлтийг оруулна.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	Хамааралгүй
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө <ul style="list-style-type: none"> <li>- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ</li> <li>- Эрсдлийн үед авах арга хэмжээ</li> <li>- Учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ</li> <li>- Хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ</li> </ul>	Хамааралгүй
3.2	1. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	1. Шатах тослох материал: 3 төрөл, 132.0 тонн 2. Хамааралгүй
3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ <ul style="list-style-type: none"> <li>• Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/</li> <li>• Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/</li> <li>• Аюултай хог хаягдал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ - 1.55 тонн</li> <li>• Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ - 0.1 тонн</li> <li>• Аюултай хог хаягдал – аккумулятор-5ш, фильтр (агаар/тосны)-50 ш</li> </ul>

2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	1.1 сая.төг
---	-------------

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

- Доорх хүснэгтийн 4.1.2 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	43.2 сая.төг
	2. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	2.0 сая.төг
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	1.4 сая.төг
	4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	26.2 сая.төг
	5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	12.1 сая.төг
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	ҮАЗ
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	0.2 сая.төг
	8. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	-
	9. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	0.2 сая.төг

## ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг байгаль орчны мэдээллийн санд оруулна.
- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

№	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	
	Тосгон	
	Хог хаягдлын цэгийн байршил	
	Аюултай хог хаягдлын агуулахын байршил	
	Хаягдлын далан	
	Химийн бодисын агуулахын байршил	
	Орчны хяналт шинжилгээний дээж авах	
	Хяналтын цэгийн байршил	
	Тухайн жилд хуулах хөрс	
	Гадаад, дотоод овоолго	
	Техникийн нөхөн сэргээлтийн талбай	
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай	
	Гүний худгийн байршил	
	Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил	

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД  
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэх багананд “тодорхойлсон”, “тодорхойлоогүй”, “хамааралгүй” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөл-лийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
6.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах - амьдрах орчинг хомсдуулах - нөөцийг бууруулах	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
6.5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс - Хамгаалах - Нүүлгэн шилжүүлэх	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	

**ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “**тийм**”, “**үгүй**” хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтнүүд “**хангалттай**” “**хангалтгүй**” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
7.1.Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	1	Тийм	Тийм	
7.2.Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	3	Тийм	Тийм	
7.3.Нөхөн сэргээлтийн арга хэмжээ <ul style="list-style-type: none"> <li>• техникийн/ га эзлэхүүн</li> <li>• биологийн /га</li> </ul>	Тех – 0.25 га	Тийм	Тийм	
7.4.Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	2	Тийм	Тийм	
7.5.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	3	Тийм	Үгүй	
7.6.Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	-	-	-	
7.7.Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	2	Үгүй	Үгүй	



**НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж (удаа)	Г. Төсөв (сая.төг)
1. Агаар	3	- ШТМ-ын агуулах - Карьерийн дэргэд - Тээврийн замын дэргэд	1 удаа	0.04
2. Хөрс	5	- Нөлөөлөлд өртөөгүй талбай - Шимт хөрсний овоолго - Нөхөн сэргээлт хийгдсэн талбай - ШТС орчимд - Хог хаягдал бохирын цэгийн орчимд	1 удаа	0.08
3. Ус	2	- Эргэлтийн усан сан - Унд ахуйн уснаас	1 удаа	0.08

**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө**

**АГУУЛГА**

<b>БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>2</b>
1.1. Төслийн нэр	2
1.1.1. Ашигт малтмалын дугаар	2
1.1.2. Төсөл хэрэгжүүлэгч	2
1.1.3. Төслийн байршил	2
1.1.4. Ордын нөөцийн тооцоо	4
1.1.5. 2024 онд ашиглах нөөц	5
1.2. ИЛ УУРХАЙ	5
1.2.1. Уурхайн ашиглалтын технологи, үндсэн хэмжээс	7
1.2.2. Уурхайн ашиглалт	7
1.2.3. Тоног төхөөрөмж	7
1.2.4. Ухаж ачих, тээвэрлэх процесс	7
1.2.5. Уурхайн дотоод тээвэр	8
1.2.6. Овоолгын аж ахуй	9
1.3. БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ	9
1.3.1. Баяжуулалтын технологи болон 2024 оны үйл ажиллагааны бүтээгдэхүүн гаргалт	9
1.3.2. Баяжуулах үйл ажиллагаа	9
1.3.3. Хаягдлын сан	9
1.4. ДЭД БҮТЭЦ	10
1.4.1. Уурхайн хотхон	10
1.4.2. Уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй	10
1.5. ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ	11
1.5.1. Ашиглалтын нэгдсэн зардал	11
1.5.2. Цалингийн сангийн тооцоо	11
1.6. 2024 онд хийгдэх ажлын хэмжээ	11
<b>БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>13</b>
2.1. Цаг уур, уур амьсгалын үзүүлэлтүүд	13
2.2. Гадаргын болон газрын доорх ус	14
2.3. Ордын гидрогеологийн нөхцөл	15
2.4. Хөрсөн бүрхэвч	16
2.5. Ургамлан нөмрөг	17
2.6. Амьтны аймаг	17
<b>БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b>	<b>18</b>
<b>БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ</b> .....	<b>18</b>
<b>БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>19</b>
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	20
5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	21
5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
5.6. ОСОЛ эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
5.8. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	24
5.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	26
5.10. Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	26
5.11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	27

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн нэр

Төслийн нэр: “Шаазгайт, Жалга 1,2 алтны шороон ордыг ил аргаар ашиглах

#### 1.1.1. Ашигт малтмалын дугаар

MV-000396, S=56.49 га

#### 1.1.2. Төсөл хэрэгжүүлэгч

Төсөл хэрэгжүүлэгч: “Хатантүшиг трейд” ХХК,

- Регистрийн дугаар: 2839385;
- Улсын бүртгэлийн дугаар: 9011020148;
- УБ хот, СХД, 20-р хороо, Сонсголон /18133/, 25 тоот;
- Утас: 99101131, 99991131

#### 1.1.3. Төслийн байршил

“Хатантүшиг трейд” ХХК-ийн эзэмшиж буй MV-000396 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай буюу Шаазгайт, Жалга 1,2 алтны шороон орд нь Дархан-Уул аймгийн Шарынгол сумын нутагт оршино.

Шаазгайт, Жалга 1,2 алтны шороон орд нь Улаанбаатар хотоос баруун хойш 210 км, Дархан-Уул аймгаас 70 км зайтай. Шарынгол сум нь Хэнтийн нурууны салбар уул Дархан-Уулын өвөрт далайн түвшнээс дээш 920 м өндөрт оршдог 56,49 га нутаг дэвсгэртэй. Шаазгайт, Жалга 1,2 алтны шороон орд нь нүүрсний уурхайн тосгоны төвөөс 7 км зайтай оршино.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Дархан-Уул аймгийн Шарынгол сумын нутагт Монгол Улсын байр зүйн зургийн М-48-105 хавтгайд байрладаг.

*Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл*

№	Уртраг WGS84			Өргөрөг WGS84			UTM	
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек	Y	X
1	106	27	29.44	49	16	31.43	606063.8483	5459094.068
2	106	27	31.6	49	16	20.23	606114.1638	5458749.062
3	106	27	33.33	49	16	20.37	606149.0357	5458754.06
4	106	27	35.44	49	16	8.04	606199.0221	5458374.143
5	106	27	48.45	49	16	4.8	606463.8494	5458279.177
6	106	27	45.85	49	16	0.79	606413.7068	5458154.335
7	106	28	0.34	49	15	57.04	606708.7619	5458044.211
8	106	27	58.76	49	15	54.16	606678.5582	5457954.66
9	106	27	48.72	49	15	57.51	606473.6635	5458054.173
10	106	27	44.71	49	15	55.14	606394.0452	5457979.422
11	106	27	41.51	49	15	56	606328.8653	5458004.727
12	106	27	34.27	49	15	45.56	606188.782	5457679.522
13	106	27	23.25	49	15	48.77	605964.1653	5457774.349
14	106	27	22.2	49	15	47.01	605943.9927	5457719.593
15	106	27	22.93	49	15	46.51	605959.0428	5457704.437
16	106	27	16.83	49	15	40.92	605839.0877	5457529.449

**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө**

17	106	27	16.09	49	15	41.1	605824.0255	5457534.72
18	106	27	6.15	49	15	31.91	605628.5884	5457247.079
19	106	27	6.32	49	15	33.92	605630.8325	5457309.212
20	106	27	8.7	49	15	37.45	605676.8398	5457419.14
21	106	27	10.53	49	15	39.35	605712.6971	5457478.521
22	106	27	13.14	49	15	42.51	605763.5692	5457577.113
23	106	27	12.74	49	15	45.84	605753.5083	5457679.785
24	106	27	13.07	49	15	48.39	605758.6634	5457758.655
25	106	27	15.68	49	15	51.32	605809.6684	5457850.146
26	106	27	17.9	49	15	54.67	605852.5408	5457954.454
27	106	27	17.24	49	15	57.13	605837.7415	5458030.161
28	106	27	25.83	49	16	9.3	606004.0847	5458409.304
29	106	27	24.15	49	16	19.69	605963.9548	5458729.484
30	106	27	21.17	49	16	19.4	605903.9149	5458719.369
31	106	27	19.77	49	16	26.12	605871.6315	5458926.333
32	106	27	21.14	49	16	26.97	605898.8065	5458953.114
33	106	27	22.22	49	16	29.37	605919.1998	5459027.644
34	106	27	21.64	49	16	33.48	605905.0366	5459154.332
35	106	27	20.71	49	16	34.59	605885.5868	5459188.246
36	106	27	21.53	49	16	38.73	605899.6913	5459316.405
37	106	27	29.93	49	16	39.35	606069.0298	5459338.822
38	106	27	30.94	49	16	31.58	606094.0652	5459099.284



**Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байршилг харуулсан тойм зураг**

“Хатантүшиг трейд” ХХК нь 369А дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй бөгөөд "Гол мөрний урсац, бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сангийн газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль"-ийн дагуу ашиглалтын талбайн зарим хэсэг хасагдан лицензийн талбайн булангийн цэгүүдэд өөрчлөлт оруулсан байдаг.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө



*Зураг 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн сансрын зураг*



*Зураг 3. Ашиглалтын талбайн одоогийн байдал*

#### 1.1.4. Ордын нөөцийн тооцоо

Нийт талбайн хэмжээнд 13 блокт бодит В зэргээр шликээр 169.0 кг, химийн цэврээр 151.25 кг алтны нөөц тогтоов. Ордын нөөцийн нэгдсэн тооцоог дараах хүснэгтэд үзүүлэв. Жич: уг орд нь 1991 онд У.Ганбаатар, Д.Базарсад нар урьдчилсан хайгуул хийж нөөцийг тогтоосон бөгөөд уг нөөцөөс нөөцийн хөдөлгөөнөөр (C1+C2)-267 кг алтны нөөц үлдсэн бөгөөд уг ордын ихэнх хэсгийг өмнөх тусгай зөвшөөрөл эзэмшигч компани ашиглаж зөвхөн 35-48 дугаар шугам хоорондох талбай үлдсэн байна. 2010 онд МУ-ын зөвлөх геологич Т.Семейхан тэргүүтэй хайгуулын анги хайгуулын ажлыг хийсний үр дүнд нөөц нь бодит В зэргээр химийн цэврээр 151.25 кг болж байна.

**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө**

Жич: 40-42 дугаар шугам, 42-44 дугаар шугамууд хоорондох ашигласан талбай болон мөн 48-р шугамнаас дээш тусгай зөвшөөрлийн хилээс гарсан хэсгийг нөөцийн тооцоонд оруулалгүй шууд хасаж тооцсон.

#### **1.1.5. 2024 онд ашиглах нөөц**

Шаазгайтын алтны шороон ордын нөөцийг УУЯ-ны ЭБМЗөвлөлийн 2015 оны 07-р сарын 07-ны өдрийн дугаар № ХХ-07-14 дүгнэлт, АМГ-ын даргын 2015 оны 08-р сарын 18-ны өдрийн Н/95 тушаалаар /бодитой/ зэргээр элсний хэмжээ 307.8 мян.м3 хөрсний хэмжээ 854.9 мян.м3, алт химийн цэврээр 151.2 кг-аар хүлээн авсан.

2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодотгол ТЭЗҮ-ний дагуу II хэсгийн С-1 – С-2 эдгээр блокуудад уулын ажил явагдахаар төлөвлөгөөнд тусгасан.

## **1.2. ИЛ УУРХАЙ**

Үйлдвэрлэлийн нөөцийг геологийн нөөцөөс ашиглалтын үед болон элс угаах технологийн процессын үед гарах хаягдлыг хасаж, хөрснөөс орох бохирдлын хэмжээг нэмж тооцоолж байна.

- Хаягдал: ашиглалтын үеийн хаягдлыг 2%-аас хэтрүүлэхгүй байхаар тооцоонд авлаа.
- Бохирдолт: Алтыг хаягдал багатай олборлох үүднээс алт агуулсан дээд давхаргын таазнаас дээш 0.2 м хөрс, мөн элсний улнаас 0.2 м доош хамт олборлолт хийнэ. Иймд ул, тааз дээрхи хэмжээний хөрсөөр мөн элсний хажуу хананаас гурвалжин хэсгээр бохирдоно.

Уг ордыг ашиглах үйлдвэрлэлийн нөөцийн элсний хэмжээ 17.92 мян.м3, дундаж агуулга 269 мг/м3, алтны хэмжээ химийн цэврээр 3.45 кг байна. 2024 оны 5 сараас бэлтгэл ажил явуулж эхлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгалаа.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
 “Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон  
 ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

*Хүснэгт 1. Үйлдвэрлэлийн нөөц/Сорьц-895/*

Геологийн нөөц									Ашиглалтын хаягдал			Бохирдолт		Үйлдвэрлэлийн нөөц						Боловсруулах хүдэр		
Блокын дугаар, Нөөцийн зэрэг	Хүдрийн биет	Блокын талбай	Хөрсний зузаан	Элсний зузаан	Хөрсний эзэлхүүн	Элсний эзэлхүүн	Дундаж агуулга	Эрдэс, Металлын нөөц	Хаягдлын хувь	Хаягдал	Хаягдал метал	Бохирдолтын хувь	Бохирдуулагч чулуулаг	Нэмэгдсэн хөрс	Хөрс хуулалт	Элсний эзэлхүүн	Дундаж агуулга	Металл /Эрдэс/- ын нөөц	Элсний эзэлхүүн	Дундаж агуулга	Металлын нөөц	
Хэмжих нэгж		м2	м	м	мян.м3	мян.м3	мг/ м3	химийн цэвэр,кг	%	мян.м3	кг	%	мян.м3	мян.м3	мян.м3	мян.м3	мг/ м3	кг	мян.м3	мг/ м3	кг	
Дугаар	0	1	2	3	4	5	6	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	
С-1	II хэсэг	5,330.00	4.80	1.6	25.58	8.53	270	2.07	2%	0.17	0.05	25	2.09	2.13	25.21	10.44	270	2.07	10.44	270	2.07	
С-2	II хэсэг	4,540.00	4.56	1.28	20.70	5.81	269	1.38	2%	0.11	0.03	31.3	1.78	1.82	20.42	7.47	269	1.38	7.47	200	1.38	
Нийт		9,870.00			46.29	14.34	270	3.45	2%	0.28		28.15	3.87	3.95	45.63	17.92	270	3.45	17.92	270	3.45	

**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө**

### 1.2.1. Уурхайн ашиглалтын технологи, үндсэн хэмжээс

**Хүснэгт 2. Ашиглалтын системийн үзүүлэлт**

д/д	Ашиглалтын системийн параметр	Хэмжээ
1	Доголын өндөр, м	2-3
2	Доголын өндөр, м/Шаазгайт дээд, Шаазгайт доод/	4-6
2	Ажлын доголын налуу, град	65
3	Ажлын бус доголын налуу, град	38
4	Траншей, съездын өргөн, м	10
5	Траншейн налуу, %	80
6	Орлын өргөн, м	15

### 1.2.2. Уурхайн ашиглалт

2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд II хэсэг С блок руу нэвтэрсэн траншей-с хөрс хуулалт, элс олборлолтын ажлыг эхлүүлнэ. Үржил шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2-0.3 метрээс ихгүй зузаантайгаар бульдозероор хуулан түрж экскаватор-автосомасвалын хослолоор ашиглалтын хилийн гадна овоолж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглана.

Хөрс хуулалтын ажил: Ил уурхайг нээх буюу эхлэх үед С блоккийн хөрсний чулуулгыг экскаватор-автосомасвалын хослолоор олборлолтын талбайн гадна гадаад овоолго хийнэ. Хөрс хуулалт болон элс олборлолтын ажил хийж тухайн хэсэгт тодорхой хоосон орон зай гаргаж, гарсан орон зайд тунаах нуурууд үүсгэх мөн экскаватор-автосомасвалын хослолоор дотоод овоолго хийх замаар хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

Элс олборлолтын ажлыг экскаватор-автосомасвалын хослолоор олборлохоор төлөвлөв.

### 1.2.3. Тоног төхөөрөмж

Hyundai 4500 LC маркийн 2.2м<sup>3</sup> утгуурын багтаамжтай 1ш экскаватор, Hyundai 2800 KLC маркийн 1.2м<sup>3</sup> утгуурын багтаамжтай 1ш экскаватор, Doosan DL-450 маркийн 5м<sup>3</sup> утгуурын багтаамжтай 1ш утгуурт ачигч, HOWO маркийн 25н даацтай 3ш автосамосвал байлгахар тооцсон. Эдгээр тоног төхөөрөмжүүдийг ашиглалтын саруудад элс олборлолт, хөрс хуулалт, баяжуулалт, овоолгын ажлуудад ашиглана.

**Хүснэгт 3. Ил уурхайн тоног төхөөрөмжийн иж бүрдэл /уурхайд/**

Ажлын зориулалт	Марк	Тоо, ш
Хөрс хуулалт болон олборлолтонд	Хьюндэй 4500LC экскаватор	1
Хөрс хуулалт болон олборлолтонд	Хьюндэй 2800 KLC экскаватор	1
Хөрс болон элс тээвэрлэлт	Хово /25 тн/	3
Туслах ажилд	Доосан DL-450 утгуурт ачигч	1
Нийт		6

### 1.2.4. Ухаж ачих, тээвэрлэх процесс

Ил уурхайн дээд давхаргын хөрс хуулалт болон олборлолтын ажилд урвуу утгуурт 2.2 м<sup>3</sup> шанаганы багтаамжтай Hyundai 4500 LC маркийн экскаватор болон Hyundai 2800 KLC экскаватор тус тус ажиллана.

**Хүснэгт 4. Хөрс, Элс ачих экскаваторын бүтээлийн тооцоо**



**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хөрс хуулалт	Элс олборлолт
1			3600	3600
2	Шанаганы багтаамж	м <sup>3</sup>	2.2	1.2
3	Экскаваторын техникийн бүтээл 1 цаг	м <sup>3</sup>	137	62
4	Ээлжийн цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.85	0.85
5	Ээлжинд ажиллах хугацаа	цаг	10	10
8	Ээлжийн бүтээл	м <sup>3</sup>	1028	467
9	Хоногийн бүтээл	м <sup>3</sup>	2057	935
10	Сарын бүтээл	м <sup>3</sup>	51425	23375
11	Жилийн бүтээл	м <sup>3</sup>	102850	46750
<b>12</b>	<b>Мото цаг</b>	<b>м/ц</b>	<b>1748</b>	<b>1538</b>

### 1.2.5. Уурхайн дотоод тээвэр

Уурхайд хөрс болон элс тээвэрлэлтийн ажил нь автотээвэрээр хийгдэнэ. Шимт хөрсийг уурхайн зүүн талд 280м зайд үржил шимт хөрсний овоолго үүсгэнэ. Хөрс хуулалтын ажилд Hyundai 4500 LC экскаватор, Howo маркийн өөрөө буулгагчууд ажиллана.

#### *Хүснэгт 5. Өөрөө буулгагчийн бүтээлийн тооцоо*

№	Үзүүлэлт	Х. нэгж	Хөрс хуулалт	Элс олборлолт
1	Автосамосвалын марк		Howo	Howo
2	Тээврийн зай, нэг талдаа	м	280	280
3	Автосамосвалын ачаатай явах хурд	км/цаг	25.0	25.0
4	Автосамосвалын хоосон явах хурд	км/цаг	30.0	30.0
5	Ачилт хийх экскаватор		4500 LC	2800 KLC
6	Экскаваторын шанаганы багтаамж	м <sup>3</sup>	1.6	1.6
7	Экскавацлалтын итгэлцүүр		0.9	0.9
8	Чулуулгийн эзэлхүүн жин	тн/м <sup>3</sup>	1.00	1.00
9	Самосвалын тэвшний эзэлхүүн	м <sup>3</sup>	14.4	14.4
10	Самосвалын паспортын даац	тн	25.0	25.0
11	Утгалтын тоо(техникийн даацын нөхцөлөөр)		18	18
12	Самосвалын бодит даац	тн	20.00	20.00
13	Самосвалын даац ашиглалтын коэффициент		1.0	1.0
14	Рейсийн хугацаа	сек	383.5	383.5
15	Ачилт хийх хугацаа	сек	358	358
16	Хөдөлгөөний хугацаа	сек	47.5	47.5
17	Ачаагаа буулгах	сек	60.0	60.0
18	Сэлгээ хийх, хүлээх хугацаа	сек	100.0	100.0
19	Нэг цагт гүйцэтгэх рейсийн тоо	удаа	9	9
20	Ээлжийн үргэлжлэх нийт хугацаа	цаг	12.0	12.0
21	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1	2
22	Тойрох үзлэгийн хугацаа	цаг	0.5	0.5
23	Ээлжийн сул зогсолт (өдрийн хоол, тос түлш нэмэх)	цаг	1	1
24	Өдрийн сул зогсолт	цаг	0.5	0.5
25	Хоногт ажиллах хугацаа	цаг	10.0	10.0
26	Цаг Ашиглалтын тооцооны коэффициент		0.83	0.83
27	Техникийн бэлэн байдлын коэффициент		0.83	0.83
28	Цагийн бүтээл	м <sup>3</sup>	90	83
29	ээлжийн бүтээл	м <sup>3</sup>	747	688

**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө**

30	Хоногийн бүтээл	м3	1,494	1,377
31	Гүйлт	км	13,553	8,132

### 1.2.6. Овоолгын аж ахуй

Хөрсний дээд давхаргын хоосон чулуулгийг экскаватороор хуулж гадаад болон дотоод овоолгод тээвэрлэн асгаж овоолго үүсгэх бөгөөд түүнийг түрж тэгшлэх, шимт хөрсөөр хучих зэрэг техникийн нөхөн сэргээлтийг ажлыг мөн гүйцэтгэнэ. 2021 оны уулын ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд ил уурхайн хөрсийг авто тээврээр гадаад болон дотоод овоолгуудад овоолго үүсгэнэ.

## 1.3. БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ

### 1.3.1. Баяжуулалтын технологи болон 2024 оны үйл ажиллагааны бүтээгдэхүүн гаргалт

Дараах хүснэгтэд үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуух бүтээгдэхүүн гаргалтын хэмжээг ажиллах сар тус бүрээр үзүүлэв.

*Хүснэгт 6. Бүтээгдэхүүн гаргалт /2024 он/*

№	Ажлын төрөл	Хэмжих нэгж	2024 он
1	Элс олборлолт	м <sup>3</sup>	17,920
2	Элсэн дэх алтны агуулга	мг/м <sup>3</sup>	270
3	Элсэн дэх алтны хэмжээ	кг	3.45
4	Баяжуулах элс	м <sup>3</sup>	17,920
5	Баяжуулалтанд ачааллах элсэн дэх алтны дундаж агуулга	мг/м <sup>3</sup>	270
6	Баяжуулалтанд ачааллах элсэн дэх алтны хэмжээ	кг	3.45
7	Металл авалт	%	88%
8	Гүйцээн баяжуулалт /химийн цэвэр/	кг	3.036

### 1.3.2. Баяжуулах үйл ажиллагаа

-20+0мм-ийн ширхэглэлтэй элсийг хоригт цоргоор баяжуулна. Энд цул алт болон жижиг ширхэглэлтэй алтнууд нь хоригт цоргоны гүн дүүргэлтийн хоригуудад баяжигдах юм. Тодорхой хугацааны дараа /20 цаг орчим/ хоригт цорго баяжмалаар дүүрнэ. Түүний дараа хоригт цоргонд элс, ус өгөлтийг зогсоож алттай баяжмалыг ялган дараачийн төхөөрөмжид ачаална. Энэхүү баяжмалыг нам дүүргэлтийн хоригийн тусламжтай баяжмал дахь алтны агуулгыг нэмэгдүүлэх ба баяжуулах ширээнд ачаалж хаягдал, завсрын бүтээгдэхүүн, баяжмал гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн гаргана. Баяжуулах ширээний завсрын бүтээгдэхүүнийг дахин ширээнд ачаалах бөгөөд баяжмал нь агуулга өндөртэй шлихийн алт байна.

### 1.3.3. Хаягдлын сан

Скрубберээс гарсан +20мм ширхэглэлтэй бүтээгдэхүүн нь галийн овоолгод хаягдана. Нам дүүргэлтийн шлюз, сэгсрэх ширээний хаягдлууд нь эфель болж эфелийн овоолгод тус тус хаягдана. Хаягдлын санд хуримтлагдсан технологийн ус нь 2 тунаах нуураар дамжин цэвэршээд эргэн технологид хэрэглэгдэнэ.

*Хүснэгт 7. Усны хэрэглээ, баланс*

**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024
1	Элсний хэмжээ	м <sup>3</sup>	17,920
2	1м <sup>3</sup> Элс угаахад шаардлагатай ус	л/м <sup>3</sup>	4
3	Технологийн усны хэрэгцээ	м <sup>3</sup>	71,680
4	Үйлдвэрлэлийн цэвэр усны хэрэгцээ /20%/	м <sup>3</sup>	14,336
5	Нэгж усны төлбөр /Үйлдвэрлэлийн зориулалт/	төг	580.44
Үйлдвэрлэлийн усны зардал		сая.төг	8.8

Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээнд зааснаар Хараа голын сав газрын гадаргын усны төлбөр 580.44 төгрөгөөр тооцсон.

“МОНГОЛ-УС” ТӨХК-ийн 2015 оны 10-р сарын 14-ны өдрийн №320 дугаартай Усны дүгнэлт хүргүүлэх тухай гэсэн гарчигтай албан бичиг Хатантүшиг трейд ХХК-д ирсэн. 1м<sup>3</sup> усны төлбөр 580.44 төг байхаар тооцсон. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд усны зардлаа дээрх зардлаар тооцсон.

#### **1.4. ДЭД БҮТЭЦ**

Тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны хувьд Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт харьяалагдах ба Улаанбаатар хотоос баруун хойш 230км, Шарын голын уурхайгаас зүүн хойш 3-4км Шаазгайтын голын хөндийд байрлана.

##### **1.4.1. Уурхайн хотхон**

Хотхон нийт 19 объектоос бүрдэх бөгөөд ажилчдын сууц-6, ХАБЭА танхим-1 байдаг. Амрах байр нь дотроо 2 өрөөтэй өрөө бүрд 4 ажилчин амрах бөгөөд нийт хүчин чадал нь 40 хүний багтаамжтай. Эрүүл ахуйн норм стандарт хангасан болно. Дорнод аймгийн нутаг дэвсгэр нь ойн түймрийн өндөр эрсдэлтэй бүс тул гал түймрийн аюулаас хамгаалж, галын цэг, тамхи татах цэг, хотхон тойрсон галын аюулын зурвас байгуулахаар төлөвлөсөн

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгаснаар шатах тослох материалын хаягдлын цэг, засварын талбай, ШТС, ахуйн хог хаягдлын цэг, нийтийн бие засах газар, ахуйн бохирын цооног зэргийг сум сум орон нутгаас зөвшөөрөл авч байгуулна.

Хотхонд ажилчдын эрүүл мэнд хөдөлгөөний дутагдал зэргээс хамгаалах үүднээс спорт амралтын байгууламж болох, сагс, волейбол, билиард турник, бодибилдингийн тоноглол, нийтийн гимнастикийн талбай, зурагт самбар, ХАБЭА сурталчилгааны самбар зэргийг ил талбайд байрлуулахаар төлөвлөж ажиллана.

##### **1.4.2. Уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй**

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд уулын үйлдвэрт мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны /ХХАА/ нэгдсэн зааврыг мөрдлөг болгон ажиллана.

- Ажиллагсад ХХАА-ны зааварчилгааг заавал өгч шалгаж байж ажилд оруулна.
- Ээлжид гарахын өмнө гүйцэтгэх ажлын даалгавар өгч түүнтэй холбогдсон аюулгүй ажиллагааны зааварчилгааг урьдчилан өгч байна.
- Техник тоног төхөөрөмжүүдийг тогтмол үзлэгт оруулан илэрсэн доголдол дутагдлыг дор бүр нь арилгуулж байж ажилд оруулна.

**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө**

- Ажиллагсдыг хээрийн ажлын үед ба ажил дууссаны дараа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулна.
- Ажлын байр орон сууц, хоолны газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын хэмжээнд байлгах арга хэмжээг тогтмол авч ажиллуулж байна.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон галын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн төлөвлөгөө:

- Уурхайн бүх ажиллагсдад хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрийн дотоод журмаар заавар зөвлөгөө өгнө.
- Уулын ажлыг төлөвлөгөөнд тусгасны дагуу осол авааргүй хийнэ.
- Ажил эхлэхийн өмнө тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалган үзэж хаалт хамгаалалтыг хийж аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байна.
- Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг графикт хугацаанд осол авааргүй хийнэ.
- Ажлын байранд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх эмийн хэрэгсэлтэй байлгана.
- Галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгааг ажиллагсдад өгч, гал түймрийн үед ажиллах зохион байгуулалт хийж мөрдөнө.
- Гал унтраах хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж ажлын байранд байрлуулна.
- Шатах тослох материалыг тусгай байранд хадгална.
- Хэрэглэсэн арчих материал тостой зүйлүүдийг тусгай саванд хадгална.
- Галын аюулаас сэргийлэх дохио санамж тэмдэгтүүдийг шаардлагатай газар байрлуулах ба тоног төхөөрөмжүүдийг галын хороор хангана.

## **1.5. ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ**

### **1.5.1. Ашиглалтын нэгдсэн зардал**

2024 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр нийт 497.1 сая төгрөгийн зардал тооцоолсон.

### **1.5.2. Цалингийн сангийн тооцоо**

Нийт ажилчдын орон тоо 55 байна. Нэг ажилтны сарын дундаж цалин 1,228 мянган төгрөг байна. Дараах хүснэгтэд нийт ажилчдын орон тоо болон хэсэг тус бүрийн эхний жилийн цалингийн сангийн тооцоог үзүүлээ.

**Хүснэгт 8. Ажилчдын орон тоо, жилийн цалингийн сан**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Орон тоо	2023 он
1	Удирдлагын хэсэг	сая.төг	10	50
2	Ил уурхайн хэсэг	сая.төг	30	100
3	Баяжуулалтын хэсэг	сая.төг	15	50
Нийт зардлын дүн		сая.төг	55	200

## **1.6. 2024 онд хийгдэх ажлын хэмжээ**

2024 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 17.920 мян.м3 элс олборлож, 3.036 кг алт борлуулна. Үр ашгийн шинжилгээний үндсэн тооцоололд алтны үнийг 1кг алтны үнэ 180.0 сая төгрөг байхаар тооцоонд тусгасан. /1унц=31.1034768гр/. 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 546.5 сая төгрөгийн борлуулалтын орлого олж 497.1 сая төгрөгийн

**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө**

зардал гарган 49.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллана. Татвар төлсний дараах дүнгээр 44.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллана.

## БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Цаг уур, уур амьсгалын үзүүлэлтүүд

Дархан-Уул аймгийн Шарын гол сум нь байгаль цаг уурын хувьд хоногийн температурын хэлбэлзэл ихтэй эх газрын эрс тэс уур амьсгалтай бүс нутагт багтдаг. Тус сумын нутаг далайн түвшнээс дээш дунджаар 910 метр өндөр, ойт хээрийн бүсэд хамаардаг. Дархан-Уул аймгийн уур амьсгалын ерөнхий мужлалыг үйлдэхдээ таримал ба хадлан бэлчээрийн ургамлын ургах үеийн чийг, дулааны үзүүлэлтийг үндэс болгодог. Тус сумын нутаг нь уур амьсгалын мужлалын хувьд чийглэгдүү хүйтэн мужид хамаарч байна. Нарны нийлбэр цацраг 1300 кВт цаг/м<sup>2</sup> -аас бага буюу нийлбэр цацрагаар Монгол орны бага бүсэд оршдог. Хоногийн дундаж температур +10оС-аас дээш байх өдөр 135 байдаг.

#### Температур:

Агаарын температурын УАД-нь 0.7 градус дулаан, хамгийн их нь 1999 онд 44.5 градус /Шарынгол суманд 7 сард / хүрч халсан, хамгийн бага нь 2001 онд -48.5 градус /Шарынгол суманд 1 сард / хүрч хүйтэрсэн байна. Жилд дунджаар 220-230 өдөр хүйтрэлтэй байж бусад хугацаанд дулаан байдаг. УАД-аар хаврын эцсийн цочир хүйтрэл агаарт 5 дугаар сарын III-10 хоногт, намрын эхний цочир хүйтрэл 9 дүгээр сарын II-10 хоногт ажиглагддаг.

*Хүснэгт 9. Шаазгайт станцын агаарын дундаж температур /°С/*

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Сарын дундаж, °С	-22.6	-17.3	-6.0	4.4	11.3	17.8	19.9	17.4	10.5	1.2	-10.3	-19.4
Хамгийн их, °С	-17.1	-10.7	-1.5	8.0	14.8	22.8	24.1	21.5	13.8	4.6	-6.3	-13.2
Хамгийн бага, °С	-27.6	-26.1	-12.8	-1.2	7.6	14.5	17.2	14.6	7.6	-3.6	-16.3	-26.7

#### Хөрсний температурын нөхцөл, хөлдөлт, гэсэлтийн хугацаа:

Хөрс нарны илчийг дулаан улиралд ихээр шингээж, хүйтэн улиралд жиндэн хөрч дулаанаа алдаж байдаг. Хөрсний гадаргад жилийн дунджаар агаарынхаас 2-4°С дулаан байх бөгөөд өвлийн саруудад 2-3°С хүйтэн, зуны саруудад 4-7°С дулаан байдаг зүй тогтол онцлогтой. Хөрсний температурын жилийн явц агаарынхыг дагах бөгөөд харин хоногийн хувьд хамгийн дулаан, хүйтэн ажиглагдах нь 1-2 цагийн хоцрогдолтой явагддаг. Өвөл цасан бүрхүүлийн гадарга дээр (-24) – (-28)°С хүйтэрч, зун 19-24°С дулаан, халж байгаа нь хээр талын бүс нутгаас сэрүүвтэр, харьцангуй өндөрлөг байдаг онцлогтой.

*Хүснэгт 1. Шаазгайт станцын хөрсний гадаргын температур °С*

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Сарын дундаж, °С	-23.9	-18.1	-4.5	8.3	17.3	24.4	26.3	22.3	14.4	2.7	-10.6	-20.2
Хамгийн их, °С	-18.1	-9.8	0.4	13.5	23.2	29.5	32.4	26.0	19.4	5.6	-5.6	-7.3

**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар  
шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль  
орчны менежментийн төлөвлөгөө**

Хамгийн бага, °C	-28.5	-27.8	-12.0	1.1	1.4	20.1	21.2	19.0	9.8	-1.7	-17.2	-27.5
------------------	-------	-------	-------	-----	-----	------	------	------	-----	------	-------	-------

Агаарын чийг, хур тунадас


Аймгийн нийт нутгаар жилд дунджаар 330.7 мм хур тунадас унадаг бөгөөд хур тунадасны 90% нь дулааны улиралд, 10% нь хүйтний улиралд ордог байна. Хур тунадасны 30 жилийн нормоос харахад хамгийн их нь 1985 онд 472,4 мм тунадас, хамгийн бага нь 1986 онд 195.6 мм тунадас унаж байжээ.

Агаарын даралт, салхи, шуурганы горим:

Шарын гол орчмын нутаг өвөлд эсрэг циклонлог цаг агаартайгаас салхи намуун салхигүй үе олон давтагдалтайгаар агаар мандлын их даралтын орны нөлөөнд оршино. Дулаан улиралд циклонлог цаг агаар, агаар мандлын фронтын үйлчлэл идэвхжиж цаг агаар хямарч, үүлшил нэмэгдэж, хур тунадасны зонхилох хувь унадаг.

Агаар мандлын энэ нөхцөлийн улмаас орон нутгийн салхи, шуурганы үйлчлэл бий болдог. Салхины ноёлох чиглэлийг улирлын төв саруудаар авч үзвэл энэ бүсэнд өвлийн саруудад ялангуяа Дархан хотын үйлдвэрийн хэсэгт Хараа голын сав газрын өмнө чиглэлүүдийн, хаврын саруудад баруун хойноос зүүн хойд, зуны саруудад баруун өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн, намрын улиралд баруун өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн давтагдал 9.4-29 % ноёлж байдаг. Харин алтны шороон орд орчинд энэ ерөнхий ноёлол зарим сар, улиралд хувирамтгай болдог.

**Зураг 4. Салхины чиглэлийн давтагдал**



**2.2. Гадаргын болон газрын доорх ус**

Монгол орны нутагт бүрэлдэх гол, мөрний усны жилийн дундаж нөөц 30.6 шоо км, ОХУ, БНХАУ-ын нутгаас ирэх урсацыг оролцуулан тооцвол 34.6 шоо км болно. Гол мөрний бүх усны нөөцийн 49.0 хувийг /16.9 шоо км / Хойд мөсөн далайн ай сав, 11 хувийг

/3.80 шоо км/ Номхон далайн ай сав, 40 хувийг / 13.9 шоо км / Төв Азийн гадагш урсацгүй ай савын гол горхины урсац эзэлдэг байна.

Төсөл хэрэгжих Шарынгол сумын нутаг нь ус зүйн сүлжээ их бөгөөд нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт нь 0.10-0.15 км/км<sup>2</sup> -ээс доош байдаг. Гол мөрний нийлбэр урсац, газар доорх урсац, гадаргын урсац зэрэг нь 25мм-ээс дээш юм. Газар нутгийн чийгшил 200-250мм, ууршилт 200-250мм жилийн дулаан үеийн ууршилт 600-800мм гол мөрний усны булинггар 100 г/м<sup>3</sup>-аас дээш. Хатуу урсац жилд 3 м/км<sup>2</sup> дээш. Шар усны үерийн хамгийн их урсац хойд болон баруун нутгаар 10мм-ээс доош, зүүн болон өмнөд нутгийн багахан хэсгээр 250мм орчим. Борооны үерийн хамгийн их урсцын модуль 0.2-ээс дээш байдаг .

Ашиглалтын талбайд Шарын гол, Шаазгайт, Шивэрт, Хавчуу зэрэг байнга усан урсгалтай голууд үйлчлэх бөгөөд хамгийн хамгийн том нь Шарын гол юм. Голуудын усан урсгал тогтуун 0.5-0.8м/сек, гольдролын өргөн 5м, гүн нь 0.6-1.0м хүрнэ. Татмын өргөн нь 1-3км, усны зардал 8-25л/сек-ийн хооронд хэлбэлздэг. Шаазгайт, Шивэрт голуудын урт нь ойролцоогоор 13км үргэлжлэх бөгөөд жилийн дөрвөн улиралд тогтмол устай байхаас гадна, 10-р сарын сүүлээс хөлдөлт эхэлж 4-р сарын эхний хагаст гээдэг. Шаазгайтын голын усны түвшний үнэмлэхүй өндөр хайгуулын 28-р шугамын орчим 938.7м байдаг. Шаазгайт, Шивэрт голуудын гольдролын өргөн 0.5-2.0 м, гүн нь 0.4-1.0м, усны зардал 0.6м<sup>3</sup>/сек ба бороо хур элбэгтэй үед 1-3м<sup>3</sup>/сек хүрдэг. Эдгээр голууд нь татмын хэсэгтэй намгархаг юм. Голуудын ус, тунгалаг өнгөгүй, амтгүй, үнэргүй байхаас гадна гидрокарбонат, кальци-натрийн найрлагатай.

Төсөл хэрэгжих талбай нь усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүстэй 0.09 га давхцалтай, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй 26.72 га давхцалтай ба Засгийн газрын 150-р тогтоолын дагуу таван талт гэрээ байгуулан ажиллаж байна

---

### **2.3. Ордын гидрогеологийн нөхцөл**

---

Тус талбай нь Хангай-Хэнтийн гидрогеологийн мужийн Орхон голын сав газрын хэмжээнд, түүний баруун гар талуудын цутгалын нэгэн болох Шарын голын сав газрын дунд-дээд хэсэгт байрлана. Өмнөх жилүүдэд явуулсан хайгуулын ажлын явцад хийгдсэн гидрогеологийн ажиглалт, туршилт болон шурф малталт, цохилтот баганат өрөмдлөгөөр илэрсэн усны түвшин хэмжилтийн үр дүнгээр талбайн гидрогеологийн талаар ерөнхий мэдээлэл хуримтлагдсан юм.

Талбайн хэмжээнд газрын доорх усыг ус агуулагч чулуулаг, хурдасны литологийн болоод дотоод бүтцийн онцлог, ус хуримтлагдан буй болсон нөхцөлийг харгалзан үзэж дараах уст бүрдлүүдээр ялгасан байна. Үүнд:

#### **Дөрөвдөгчийн настай сэвсгэр хурдас дахь уст бүрдэл**

Энэхүү уст бүрдэл нь Шарын голын хөндий, түүний зүүн цутгалууд, хуурай хөндий, жалгуудад тархах ба ус агуулагч хурдас нь дээд дөрөвдөгч орчин үеийн настай янз бүрийн хэмжээтэй хайрга, хайрганцар, элсэнцэр, шавранцар, элс болон шаврын чигжээстэй дайрга үйрмэгээс тогтоно.

Хавчуу болон Шарын голын хөндийнүүдэд цохилтот өрөмдлөг шурфээр хийсэн гидрогеологийн туршилт ажлын үр дүнд уст давхаргын түвшин голын хөндийн татмын хэсэгт 0.6-2.06м, дэнжийн хэсэгт 5.0-12.2м хүрч ус зарцуулалт 3.25-4.6л/сек болох нь



тогтоогдсон. Тэрчлэн Бурхант, Их-Өвөлжөө зэрэг хуурай хөндийнүүдийн адгаар усны түвшин 7-8м-т илрэн гарч ирдэг. Шаазгайтын хөндийн уст давхаргын түвшин голын татмын хэсэгт 0.4-4.0м, дэнжийн хэсэгт 3-12м-т хүрч уст давхаргын зузаан 25м-т хүрдэг бол түүний зүүн салаа Шивэртийн хөндийн уст давхаргын түвшин татмын хэсэгт 0.4-2.0м. Жалга-1,2-ын адгаар газар доорх уст бүрдэл илэрсэн юм. Энэхүү дэнжийн уст бүрдлийн усны түвшин 4.6-12.2м бөгөөд Шаазгайтын хөндийн уст бүрдлийн түвшинтэй ойролцоо юм. Тус талбайд тархсан газар доорх уст бүрдлүүд нь хур тунадасны нэвтжилт, гүний чулуулаг дахь ан цавын уст бүрдлүүдээс тэжээгдэх бөгөөд талбайд тархах голуудтай нягт холбоотой байна.

Ус нь гидрокарбонат-кальци-нетон болон бага зэргийн кальци-магнийн найрлагатай бөгөөд ахуйн хэрэгцээнд ашиглагдах бүрэн тохиромжтой юм.

#### Гүний чулуулгийн ан цавын уст бүрдэл

Талбайд дунд-дээд девон, дунд-дээд ордовикийн насны гүний чулуулгууд ихээр тархсан байдаг. Эдгээр гүний чулуулгууд нь газрын гадаргууд их хэмжээгээр ан цавыг үүсгэн байрлана. Ан цавшилтын зузаан нь чулуулгийн найрлага, тогтоц, тасрал эвдрэлийн байдал зэргээс хамаарч янз бүрийн гүнтэй байдаг. Газар доорх байрлах усны гүн, усжилтын байдал нь голчлон гадаргуу дахь уст цэгийн байрлал, ан цавшилтын тархалтын онцлогоос хамаарна. Тэжээгдлийн эх булаг нь гол төлөв хур тунадасны нэвчилт бөгөөд зэргэлдээх уст давхаргууд ч нөлөөлдөг ба газрын гадаргууд булаг байдлаар мөн голын хөндийн хурдасны ус агуулсан үеүүдэд шилжих замаар гадагшилна.

Төсөл хэрэгжих талбай нь газрын доорх урсцын түвшин 5-10мм/жилд нөхөн сэргээгдэх чадвартай бүс нутагт хамаарч байна.

---

#### **2.4. Хөрсөн бүрхэвч**

Тус орд газар нь нь Шарын голын хөндий болон түүний дэнж орчмын газрыг хамарна. Энэ газар нь хөрс-газарзүйн мужлалаар Хэнтийн захын 39-р тойрогт хамрагддаг. Ашиглалтын талбайнууд нь уулын хоорондох хөндийн өргөн дэнж, хотгороор байрлана. Энэ газарт олборлолтын үйл ажиллагаа явагдаад 8 жил болсон ба орчны газар нь уурхайлалтад өртөгдөж, уул уурхайн ашиглалтаас эвдрэлд орсон газарт хамаарна.

Талбайн хэмжээнд тархсан дээрх хөрсний химийн шинжилгээний дүнгээс харахад нийт хөрсний урвалын орчин рН-7,99-8,54 хүрч сул шүлтлэгээс шүлтлэг орчинтой байна. Хөрсөн дэх үржил шимийн гол үзүүлэлт болох ялзмагийн агууламж өндөртэй 4,17-8,27%-ийн хооронд хэлбэлзэнэ. Нийт хөрс карбонат бага хэмжээгээр агуулсан байгаа бол хужирлаг бараан хөрс карбонат ихтэй, цахилгаан дамжуулах чанар илүүтэй, давс агуулснаар бусад хөрснөөс онцлогтой ялгаатай байна. Шингээгдсэн суурийн нийлбэр талхадсан аллювийн бараан хөрсний дээд давхаргад бага хэмжээтэй бусад хөрсөнд 26,3-35,8мг/эква хооронд хэлбэлзэж, сууриудаас кальцийн катион зонхилно. Ургамалд хялбар ашиглагдах хөдөлгөөнт фосфорын агууламжаар дунд болон дундаас дээш хангамжтай, солилцоот кали өндөр агуулсан байна. Энэ газрын хөрс- шороо манай орны сайн чанарын хөрстэй газрын нэг юм. Хөрсний механик бүрэлдэхүүний шинжилгээний дүнгээр нийт хөрсний үе давхарга хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, хөрсөн дэх “физик шавар”-ын агууламж 20-23%-ийг бүрдүүлж байна. Хөрсөн дэх янз бүрийн ширхэгтэй элсэн фракци 70-80%-ийг бүрдүүлж байна. Үйл ажиллагаа эхэлснээс хойш 35.45 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн ба үүний 28.93 га-д биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгээд байна. Нөхөн сэргээлт хийсэн талбайд 2 зүсэлт хийсэн ба шимт хөрсний зузаан дунджаар 18 см,

хөрс их нягтралтай, чулуу ихтэй байгаагаар ялгаатай байна. Хөрсний хими шинж чанараар анхдагч хөрсний хэмжээнд ойролцоо шинж чанартай, ялзмагын хэмжээгээр арай бага, шүлтлэг чанараар илүүтэй байгаагаар ялгаатай байна. Нөхөн сэргээлт хийсэн талбайн хөрсний үржил шимийн стандартын хэмжээнд хүрсэн үзүүлэлттэй байна.

---

## 2.5. Ургамлан нөмрөг

---

“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон орд” нь Монгол улсын нутаг дэвсгэрийн баруун хэсэгт байрлах ба засаг захиргааны хувьд Дархан-Уул аймгийн Шарынгол сумын нутаг дэвсгэрт хамаарна. Уг төсөл хэрэгжих талбай нь Монгол орны ургамал-газар зүйн мужлалаар Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрог багтаж байна.

Тус ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд 2016 оноос хойш 35.45 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн ба үүний 28.93 га-д биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгч акт үйлдүүлсэн байдаг.

---

## 2.6. Амьтны аймаг

---

Монгол Улсын байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин нэрээр), Де Нэйче Консерванси (TNC) байгууллагаас хамтран боловсруулсан Экологийн бүс нутгийн үнэлгээний тайланд “Зээлдүүлэгчийн гүйцэтгэлийн стандарт: Чухал амьдрах орчин”-ийн шаардлагыг биелүүлэх зорилгоор нийт амьдрах орчныг өөрчлөгдсөн, байгалийн буюу хэвийн, чухал гэж ангилсан. Үүний дагуу төслийн талбайг давхцуулж үнэлгээг хийхэд бүгд өөрчлөгдсөн ангилалд хамаарч байна.

Энэхүү төсөл хэрэгжих талбай нь Дархан-Уул аймгийн Шарынгол сум нутаг хамаарах ба амьтны газарзүйн мужлалын хувьд Монгол Дагуурын тойрогт багтана. (А.Г.Банников, 1954).

Монгол Дагуурын тойрог нь хөхтний газарзүйн мужлалаар Монгол-Түвдийн их мужийн Монголын хээр ба ойт хээрийн дэд мужийн Монгол-Дагуурын тойрогт хамаарагдана. Иймээс энэ нутагт аж ахуйн аливаа үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчинд бага нөлөөлөх технологийг хэрэглэх, тэнд байгаа ховордож буй болон нэн ховор амьтдыг хамгаалах шаардлагатай.

### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

*Хүснэгт 10. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл /Нийт төсөл хэрэгжих хугацаанд/*

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх Хугацаа
1	Хөрс хуулалт	Газрын хөрс, бэлчээр, агаар	10,025 м <sup>3</sup> үржил шимт хөрс, 282.75 мян.м <sup>3</sup> үндсэн хөрс хуулалт хийж хоосон орон зай үүсгэн	Хүчтэй	Төсөл хэрэгжих нийт хугацаанд
2	Элс олборлолт, баяжуулалт	Геологийн тогтоц, гүний ус, агаар	47.12 мян.м <sup>3</sup> алт агуулсан элс олборлоно. Угаан баяжуулахад нийт дунджаар 231.31 м <sup>3</sup> /хоног ус зарцуулна.	Хүчтэй	
3	Тээвэр	Хөрсөн бүрхэв, агаар, ургамлан нөмрөг	Элс болон хөрсийг дунджаар 400 м зайд тээвэр хийнэ. Тухайн тээврийн замын усалгаанд хоногт дунджаар 9.60 м <sup>3</sup> ус ашиглана.	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих хугацаанд
4	Овоолго	Агаар, шимт хөрс	Ашиглалтын жилийн хугацаанд ил уурхайгаар нийт 20.27 га талбай эвдрэлд орох бөгөөд карьерийн дундаж гүн 6 м хүрэх бөгөөд Ашиглалтын явцад зэрэгцээд дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийх зарчмаар явж нөхөндүүргэлт хийнэ:	Хүчтэй	Төсөл хэрэгжих нийт хугацаанд
5	Барилга байгууламж, дэд бүтэц	Хөрс, шимт хөрс	1. Уурхайн оффис 2. Сэлбэгийн агуулах 3. Засварын газар 4. Угаалга, душ сайн 5. Цайны газар 6. Ажилчдын байр 7. Амралтны талбай 8. Ариун цэврийн газар 9. Бохирын хэсэг	Дунд зэрэг	Нийт төслийн хэмжээнд

### БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү төслийг хэрэгжүүлэх үед технологийн онцлогоос хамааран газрын хөрс, түүний дээрх ургамал, газрын хурдас болон агаар мандалд тоос босох зэрэг сөргөөр нөлөөлөх тул байгаль орчны мониторингийг тогтмол хийх, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилсан сэргийлэх ажлуудыг байгаль хамгаалах төлөвлөгөө, санхүүжилтдээ тусган гүйцэтгэж ажиллана.

Мөн орон нутгаас ирүүлсэн Зулзагын голын нарсан ойг тэлэх ойжуулалтын ажлыг 26 га талбайг хамруулан энэ онд 5000 ширхэг мод тарих ажлыг зохион байгуулж ажиллана.

## БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

*Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт	
<b>Агаарын чанар</b>										
1	Тоосжилт болон бохирдуулагчийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Уурхайн технологийн замыг усалж чийглэх, (тодорхой ажлын график гаргах ба хуурайшилттай үед усалгааны хугацааг ойртуулах)	Элс болон хөрс тээврийн зам	км	-	Элс болон хөрс тээвэрлэх зам	ҮАЗ	Төсөл хэрэгжих хугацаанд өдөр бүр Уурхайн бэлтгэл шатанд	ЗТБХБ-ын сайдын 2011 оны 216 тоот тушаал. MNS4585:2007	
2		Уурхайн замуудад хайрга чулуу дэвсэх зэргээр технологийн замыг сайжруулж тоос босохоос хамгаалах	Элс тээврийн зам	км	-					
3		Уурхайн талбайд ажиллах авто тээврийн хэрэгслийн хурдыг /40км/ боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Төслийн хүрээнд	-	-	-	-	Уулын ажлын үед		-
4		Уурхай дотор замыг тэмдэгжүүлж, засаж сайжруулж байх	Төслийн хүрээнд	Ширхэг	-	-	0.4	Уурхайн бэлтгэл шатанд		Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007 MNS 5919:2008
<b>Гадаргын ба газрын доорх усны нөөц</b>										
1	Ус шавхан зайлуулалтын улмаас газрын доорх усанд хомстол үүсэх	Ус ашиглах гэрээг байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ	Уурхайн бэлтгэл шатанд	Усны тухай хууль 31.2 зүйл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль Усны тухай хуулийн 24.2-р заалтны	
2		Ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулах.	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ			
3		Ус ашигласан төлбөрийн улирал бүр төлж байх	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ			
4		Хаягдал усны дүгнэлт гаргуулж ажиллах	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ	4-р улиралд багтаан		
5		Элс угаан баяжуулахад ашиглагдаж буй эргэлтийн усан санг жил бүр	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ	Бэлтгэл шатанд		

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
 “Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		засаж сайжруулж лаг шаврыг зөөвөрлөж байх.						
<b>Хөрсөн бүрхэвч</b>								
2	Шатах тослох материал, шатахуун	Машин механизмын эвдрэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээг хайрган хучилттай талбайд хийх	Засварын талбайд	-	-	Үйл ажиллагааны зардал	Тухай бүрд	MNS 3307:1991, MNS 3308:1991
3	асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Ашиглагдсан тос тосолгооны материал, шатахуун асгарах, гоожих зэрэгт хяналт тавьж ажиллах, асгарсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах	Ашиглалтын талбайд	-	-	1.0	Тухай бүрд	Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
<b>Нийт</b>						<b>1.4</b>		

### 5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

*Хүснэгт 12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө*

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
<b>Техникийн нөхөн сэргээлт</b>								
1	Эвдрэлд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Өмнөх Ашиглалтын үед эвдэгдсэн уурхайн №1, 2 болон өмнөх онуудад олборлолтын үйл ажиллагаа явуулсан талбайг тэгшлэх түрэх техникийн нөхөн сэргээлт	мян.м <sup>3</sup>	4.9	0.25 га	26.2	4-р улиралд багтаан хийж гүйцэтгэх	“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5917-2008/
<b>Нийт</b>						<b>26.2</b>		

### 5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

*Хүснэгт 13. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
 “Шазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	Дүйцүүлэн хамгааллын ажил хийх талбайг орон нутгийн удирдлагатай тохиролцон сонгох	Орон нутгийн удирдлагаас санал авах	Нөхөн сэргээх талбайг орон нутагтай тохиролцох	1.0	-	7.1	2024 оны 3-р улиралд багтаан	Байгаль орчны үнэлгээний тухай хууль
2	Тэр бум мод төслийн хүрээнд хийгдэх ажил	Зулзагын голын нарсан ойг тэлэх ойжуулалтын ажлыг 26 га талбайг хамруулан	Заасан 26 га талбайд	5000	5.0	5.0	Намрын тарилтаар	
<b>Нийт</b>						<b>12.1</b>		

#### 5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Ашигт малтмалын талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй тул төлөвлөгөөнд тусгагдаагүй болно.

#### 5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Монгол улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрхзүйн хүрээнд ажиллана.

Цаашид ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс илэрсэн тохиолдолд уулын ажлыг нэн даруй зогсоож, хуулийн хүрээнд авбал зохих арга хэмжээг авч ажиллана.

#### 5.6. ОСОЛ эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төсөлд химийн бодис ашиглагдахгүй тул 2024 оны БОМТөлөвлөгөөнд тусгагдаагүй болно. Харин машин механизмд хэрэглэх түлш, шатах тослох материалаас үүсэх эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгалаа.

*Хүснэгт 14. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал*

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн нийт ажилчдад	-	1.0*	3-р улиралд багтаан	ХАБЭА

**Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
“Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил  
аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

4	нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахуудыг гадаргын урсцаас хамгаалах ба тэдгээрээр бохирдол зөөгдөхөөс хамгаалсан далан шуудуу байгуулах, засварлах	Одоо ашиглаж буй тос тосолгооны агуулах, засварын талбай ШТС	-	1.0*	Уурхайн бэлтгэл шатанд		
5	Шатах тослох материалын хадгалалт, ашиглалтаас хүний эрүүл мэнд ба хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах	Төсөлд ашиглагдах машин техник	ҮАЗ		Үйл ажиллагааны туршид	Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль, холбогдох журам, стандарт	
6		Шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт хийх	Нийт ажилчид 29 хүн	ХАБЭА зардал		3-р улиралд багтаан		
7	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж, олборлолтын үйл ажиллагаа доголдох, зогсох	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх	Нийт ажилчид 29 хүн	ХАБЭА зардал		3-р улиралд багтаан	MNS4990:2000 Гамшгаас хамгаалах хууль	
8		Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах	Нийт ажилчид 29 хүн	ХАБЭА зардал		Нормын дагуу тогтмол хугацаанд		
9		Ажилчин нэг бүрд ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалсан хор тайлах зорилгоор нормын сүү, цагаан идээгээр хангах	Хүнд нөхцөлд ажиллаж байгаа ажилчидад	Үйл ажиллагааны зардлаар		Өдөр бүр		
10		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	“Хатан түшиг Трейд” ХХК	Үйл ажиллагааны зардлаар		Өдөр бүр хэрэгжүүлэх		
<b>Нийт</b>					<b>2.0 +ҮАЗ+ ХАБЭА зардал</b>			

### 5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

*Хүснэгт 15. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө*

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
<b>1. Ахуйн хог хаягдал</b>									
1	Ахуйн хог хаягдлыг	Уурхайн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын ангилан ялгах, хооронд нь холихгүй байх.	Төслийн хүрээнд	-	-	-	-	Үйл ажиллагааны туршид	Хог хаягдлын тухай хууль

Төсөл хэрэгжүүлэгч: “Хатантүшиг трейд” ХХК.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
 “Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил  
 аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2	ангила ялгах	Хог хаягдлын түр хадгалах цэгийг тохижуулах, хашаажуулах, сайжруулах	Уурхайн хог хаягдлын цэг	-	-	-	500.0	3-р улиралд багтаан	
3		Шарын гол сумын ЗДТГ-тай Хог хаягдлын гэрээ хийх.	Төслийн хүрээнд	-	-	-	-	Ажил эхлэхтэй зэрэгцүүлэн	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдал тээвэрлэх гэрээний дагуу сар бүр хог хаягдлыг тээвэрлүүлж байх	Төслийн хүрээнд	-	-	-	-	ТҮК-ийн хуваарийн дагуу	
4		Хог хаягдал тээвэрлэх төлбөрийн Шарын гол сумын ИНХ-аас тогтоосон тарифын дагуу төлж байх	Төслийн хүрээнд	-	-	-	-	Улирал бүр	Гэрээний дагуу
6		Уурхайн бие засах газар болон хог хаягдлын цэгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг улиралд нэг удаа хийж байх	Уурхайн бие засах шазар хог хаягдал түр хадгалах цэг		100.0	-	100.0	Дулааны улирал буюу 3-р улиралд	
7		Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хэвших	Ашиглалтын талбай болон түүний ойр орчимд	-	-	-	ҮАЗ	Сар бүр тогтмол хугацаагаар	
<b>2. Аюултай хог хаягдал</b>									
1	Тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал	Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумуляторыг аюултай хог хаягдал хадгалах цэгт хуримтлуулах	Засварын газарт	-	-	-	ҮАЗ	3-р улиралд багтаан	Хог хаягдлыг тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017-05-12
3		Аюултай хог хаягдал хадгалах цэгийг засаж сайжруулах	Агуулах	-	-	-	500.0	Ажил эхлэхтэй зэрэгцүүлэн	
4		Ашигласан тос тосолгооны материалыг түр хадгалах цэгт хадгалж, дахин боловсруулах үйлдвэрт жилд нэг удаа нийлүүлэх	Төслийн хүрээнд	-	-	-	-	3-р улиралд багтаан	
		<b>Нийт</b>					<b>1100.0</b>		



## 5.8. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр


**Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (2024 он)**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	
<b>Агаарын чанар</b>								
1.1	Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> ) Азотын давхар исэл (NO <sub>2</sub> ) Нийт тоосонцор	ШТМ-ын агуулах Карьерийн дэргэд Тээврийн замын дэргэд	IX сард	1	-	40.0	Агаарын чанарт хяналт тавих	MNS5061:2001 MNS3113:1981 MNS0017.2.5.12:8988
<b>Хөрсөн бүрхэвч</b>								
2.1	Ялзмагийн агууламж, рН, давсжилт, чийгшил, NO <sub>3</sub> -N, P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O, рН, нийт азот, нийт фосфор,	- Нөлөөлөлд өртөөгүй талбай - Шимт хөрсний овоолго - Нөхөн сэргээлт хийгдсэн талбай	IX сард	1	-	80.0	Олборлолт болон үйл ажиллагааны нөлөөгөөр тухайн хөрсөн бүрхэвчийн доройтол, бохирдолт хяналт тавих,	MNS 2305-94 MNS 3298-1991 MNS 5850:2008
2.2	Нефть, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсустөрөгчид, хүнд металлын агууламж микробиологийн үзүүлэлт	- Шатахуун ачих, буулгах, машин механизмыг шатахуунаар цэнэглэх талбай, агуулах орчимд - Хог хаягдал бохирын цэгийн орчимд	IX сард	1	-			
<b>Усан орчин</b>								
1	Ca, Mg, Cl, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , NH <sub>4</sub> , HCO <sub>3</sub> , Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар,	Үйлдвэрийн ус цуглуулах эргэлтийн усан сан	IX сард	1	-	80.0	Олборлолт болон үйл ажиллагааны нөлөөгөөр тухайн ордын усны чанарын өөрчлөлт, болон бохирдолт хяналт тавих, байгальд нийлүүлж буй хаягдал ус чанарын	MNS0900:1992 MNS3935:1986 MNS3936:1986 MNS4432:1997 MNS3934:1986 MNS5667-2:2001 MNS4867:1999
2	Усанд агуулагдах хүнд металлын шинжилгээ	Хаягдлын усан сан	IX сард	1	-			
3	Усны бактерлогийн шинжилгээ: /Гэдэсний	Унд ахуйн хэрэглээний ус	IX сард	1	-			

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
 “Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

савханцар, нянгийн тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян, агааргүйтэх/					шаардлага хангаж буй эсэгт хаяналт тавих
	1 жилд			200.0	

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд дээж сорьц авах, хяналт шинжилгээ хийх цэгүүдийн байршлыг доорх зурагт үзүүлэв.



Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
 “Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон  
 ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

*Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба зардал*

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариусан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар 1.2.3.	Сар 4.5.6.7,8	Сар 9.10.11		
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах;	ҮАЗ	х	х	х	Захирал	
4	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах	ҮАЗ			Жил бүр	Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
<b>Нийт</b>		<b>200.0</b>					

5.10. Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

*Хүснэгт 18. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь*

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Шарын гол сумын Шаазгайт багийн иргэд	ИНХ-д танилцуулах	Тухайн жилд хийгдсэн ажил	4 - р улирал	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Багийн төв
2	Дархан-Уул аймгийн Байгаль орчны газар	Тайлангийн бичвэрийг хэвлэмэл байдлаар /3 хувь/	Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажрын акт болон холбогдох материал	11 - р сарын 1 дотор	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Дархан-Уул аймгийн төв
3	Төрийн захиргааны төв байгууллага	Тайлангийн бичвэрийг хэвлэмэл байдлаар /3 хувь/		12 - р сарын 1 дотор	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Төрийн захиргааны төв байгууллага
<b>Нийт</b>					ҮАЗ		

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших  
 “Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон  
 ордыг ил аргаар ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5.11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

*Хүснэгт 19. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал*

№	Арга хэмжээ	Зардал, сая төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1.4
2	Нөхөн сэргээлт хийх, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	26.2
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	12.1
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2.0
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.1
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	0.2
9	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	ҮАЗ
10	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	0.2
<b>2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал</b>		<b>43.2</b>

“Хатантүшиг трейд” ХХК-ийн “Шаазгайтын хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын хайгуулын 28-35 болон 38-42 дугаар шугам хооронд тархсан алтны үүсмэл шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаандаа 2024 онд хэрэгжүүлэн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **43.2 сая.төг** болж байна.